



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 4/23

Баян-Адарга сум

**Хяналт шалгалтын ажил зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай**

Монгол улс засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолын хавсралт Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 296 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1.Сайхан багийн хөлийн холбоо гэх газарт үйл ажиллагаа явуулж буй бичил уурхай эрхлэгчдэд хяналт шалгалт зөвлөн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Ганбат (Засаг даргийн орлогч)

Гишүүд: О.Жаргалцэцэг (Татварын улсын байцаагч)

Б.Алтаргана (Хөдөлмөр эрхлэлт халамжийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Энхцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Ө.Энхзул (Газрын даамал)

С.Батсайхан (Хэсгийн төлөөлөгч)


О.Батсуурь (Байгаль хамгаалагч)

Т.Төртүвшин (Эрүүл мэндийн төвийн их эмч)

Нарийн бичгийн дарга: Ц.Цэрэндулам (Байгаль орчны улсын
хяналтын байцаагч)

2.2025 оны 6 дугаар сарын 16- ны өдөр хяналт шалгалтын ажил зохион байгуулсугай

3.Хяналт шалгалтын ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай үр дүнтэй зохион байгуулан ажиллах ажлын явц тайланг нэгтгэн сумын засаг даргын зөвлөлд танилцуулахыг хэсгийн ахлагч Н.Ганбат, Нарийн бичгийн дарга Ц.Цэрэндулам болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.ЛХАГВАДОРЖ